- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ"
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
- "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам"-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

### **Байгууллагын дотоод хяналтын талаар**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдэж, нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шилэн дансны, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, төрийн хэмнэлтийн тухай зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн НБББББ—т бодлогод өөрчлөлт ороогүй байна. (өөрчлөлт орсон бодлогын талаар тайлбар хийх)

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 126,113.7 мянган төгрөгөөр буюу 7 хувиар өссөн/буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	6,915.8	6,915.8
Авлага	-	1,034.1	1,034.1
Бараа материал	87,083.6	116,764.7	29,681.2
Үндсэн хөрөнгө	1,688,460.8	1,776,943.5	88,482.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,775,544.3</b>	<b>1,901,658.1</b>	<b>126,113.7</b>
Өр төлбөр	-	655.3	655.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,775,544.3	1,901,002.8	125,458.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,775,544.3</b>	<b>1,901,658.1</b>	<b>126,113.7</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,915.8 мянган төгрөгт хүрч өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.;
2. Авлага дансны үлдэгдэл 1034.1 мянган төгрөгт хүрч өссөн нь татварын авлага, хүмүүсээс авах авлагыг цалингийн зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулсан нь нөлөөлсөн.
3. Бараа материал өмнөх оноос 116,764.7 мянган төгрөгт хүрч өссөн нь Алтан нутгийн хөгжил өөд ТББ, БШУГ, Төв аймгийн ЗДТГазар, БСУГ-аас 21,971.9 мянган төгрөгийн ном, сурах бичгийг үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 1,776,943.5 мянган төгрөгт хүрч өссөн нь Алтан нутгийн хөгжил өөд ТББ, БЕГ, БШУГ, БСУГ-аас 136,352.8 мянган төгрөгийн эд хогшил, номыг үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Өр төлбөр 655.3 мянган төгрөгт хүрч өссөн нь аудитын явцад ХХОАТ-ыг дутуу тайлагнасныг нягтлан бодох бүртгэлд залруулан тусгуулсан нь нөлөөлсөн;
6. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,901,002.8 мянган төгрөг болж, 125,458.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,246,580.4 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,246,580.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 87,892.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,334,473.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 23,657.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 989,976.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 212,313.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 6,201.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 989,976.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 212,313.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 6,201.0 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 629.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,320,726.8 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлын төсвийг 1,137,000.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 183,726.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,940.4	2,940.4	-	100.0
2	80312-Сургалт семинар	1,470.2	1,460.8	9.4	99.4
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,381.5	3,381.1	0.4	100.0
4	81801-Үдийн цай хөтөлбөр	57,889.1	57,888.6	0.5	100.0
5	81806 - Дотуур байрны хүүхдийн хоол	57,924.5	57,583.5	341.0	99.4
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	29,970.0	29,970.0	-	100.0
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	6,616.0	6,616.0	-	100.0
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	738,548.3	738,547.6	0.7	100.0
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	89,204.5	88,841.8	362.7	99.6
10	81848 - Түрээсийн сурах бичиг	2,031.8	2,031.8	-	100.0
<b>Дүн</b>		<b>989,976.3</b>	<b>989,261.5</b>	<b>714.8</b>	<b>99.9</b>
<b>Орон нутгийн төсвөөс</b>					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	176,420.8	176,420.8	-	100.0
2	80112-Нийтлэг үйлчилгээ	35,892.9	35,263.3	629.63	98.2
<b>Дүн</b>		<b>212,313.7</b>	<b>211,684.1</b>	<b>629.6</b>	<b>99.7</b>
<b>Нийт дүн</b>		<b>1,202,290.0</b>	<b>1,200,945.6</b>	<b>1,344.4</b>	<b>99.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 125,982.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3; 43.1.7 дугаар заалтын дагуу нийт 10 багшид хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 62,788.6 мянган, 2 багшид өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмжид 53,492.6 мянган, тогтмол зардлыг санхүүжүүлэхэд 3,500.0 мянган, нийт 119,781.2 мянган төгрөгийг олгож, 6,201.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.8-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн батлагдсан төсвийн нийт зардлын 1,202,290.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,022.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,416.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 31,203.2 мянган төгрөгөөр буюу үндсэн цалин, тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил худалдан авах зардлууд хэмнэгдсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг



тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 148 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 3 удаагийн 171,227.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 191,003.7 мянган төгрөгөөр буюу 19,776.5 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 181,146.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 180,705.7 мянган төгрөгөөр буюу 441.1 мянган төгрөгөөр дутуу, 29 удаагийн 637,057.9 мянган төгрөгийн орлогын, 10 удаагийн 103,341.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, дансны хуулгаар нотлогдохгүй болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх шаардлагагүй орлогын 3 удаагийн 41,430.8 мянган төгрөгийн, зарлагын 13 удаагийн 41,078.9 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж, ... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 7 удаагийн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралт "Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар"-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Балансын дансны жагсаалт"-ын дагуу тайлагнагдаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

2. 2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно."

**Шийдвэрлэсэн нь:** Дотоод аудитын бүрэлдэхүүнийг сайжруулах, холбогдох заавар аргачлалаар хангаж ажиллах;

3. Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүн 18 иргэн, байгууллагад 5,558.7 мянган төгрөгөөр илүү, 4 иргэн, байгууллагад 8,011.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй, үнэлгээ, нийцсэн бөгөөд зохистой байх, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 2,982.1 мянган төгрөгийг нөөцөлсөн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5. Нийт 1,576.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д " Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;" гэж заасныг үндэслэн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 600.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 6 зөвлөмжөөс, 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	6	600.0	5	600.0	83.3
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>600.0</b>	<b>5</b>	<b>600.0</b>	<b>83.3</b>

Хэрэгжээгүй зөвлөмжийг дурдах, шалтгааныг тайлбарлах

139 мэдээллийг хугацаандаа, 5 мэдээллийг байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод авсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,713,978.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,260.0 мянган төгрөгийн анхны үнэтэй” Asus” суурин компьютерын 252.0 мянган төгрөгийн элэгдлийг тооцуулж залруулсан;
- Цахим татварын тайланд илгээсэн ХХОАТ тооцох цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг, цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 3,681.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, 2022 оны 1-11 дүгээр сард нэг ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 182.0 мянган төгрөгөөр дутуу, 48 ажилтанд 655.3 мянган төгрөгийг давхардуулан илүү тооцож тайлагнасныг холбогдох тайланд залруулан бүртгүүлсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд хувьцааны ноогдол ашиг гэж 136,883.7 мянган, тусламж санхүүжилтийн орлого 694,469.5 мянган , үйл ажиллагааны зардал 39,782.5 мянган , төвлөрүүлэх шилжүүлэг 6,205.0 мянган төгрөгөөр тус тус мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав;
- Нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн хандив тусламжаар авсан хөрөнгийн дүн, үндсэн хөрөнгийн тодруулгаас 1,859.9 мянган төгрөгөөр дутуу, үр дүнгийн тайлан дахь бараа үйлчилгээний бусад зардал мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан дүнгээс 39,899.1 мянган төгрөгөөр, үр дүнгийн тайлангийн нийт дүн 7,530.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 6,829.6 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй, эргэж төлөгдөх зээл ангиллаар тайлагнасныг залруулав;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүйг холбогдох баримтыг үндэслэн тайлагнуулж залруулсан;
- Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүнг давтан тооцоолоход нэг ажилтны орон нутагт ажилласны нэмэгдлийг 385.4 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосныг авлагаар бүртгэснийг;
- Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,775,544,337.63 төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд тус тус залруулсан.

Аудитаар нийт 162.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 162.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг давтан тооцоолоогүй улмаас 28 ажилтанд 162.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.

Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4.1-т "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.", 4.4.2-т "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн Төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2016 онд баталсан НБББББ-ийг мөрдөж байгаа нь шинэчлэгдэн батлагдсан стандарт, хууль тогтоомж, заавар журамтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;"

**Өгсөн зөвлөмж:** НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж баталж мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,260.0 мянган төгрөгийн анхны үнэтэй” Asus” суурин компьютерын 252.0 мянган төгрөгийн элэгдлийг тооцуулж залруулсан;	1	252.0	1	252.0			1	252.0				
Цахим татварын тайланд илгээсэн ХХОАТ тооцох цалин, хөдөлмөрийн хөлсний дүнг, цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 3,681.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, 2022 оны 1-11 дүгээр сард нэг ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 182.0 мянган төгрөгөөр дутуу, 48 ажилтанд 655.3 мянган төгрөгийг давхардуулан илүү тооцож тайлагнасныг холбогдох тайланд залруулан бүртгүүлсэн;	1	4,336.9			1	4,336.9	1	4,336.9				
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд хувьцааны ноогдол ашиг гэж 136,883.7 мянган, тусламж санхүүжилтийн орлого 694,469.5 мянган, үйл ажиллагааны зардал 39,782.5 мянган, төвлөрүүлэх шилжүүлэг 6,205.0 мянган төгрөгөөр тус тус мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав;	1	877,340.7			1	877,340.7	1	877,340.7				
Нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн хандив тусламжаар авсан хөрөнгийн дүн, үндсэн хөрөнгийн тодруулгаас 1,859.9 мянган төгрөгөөр дутуу, үр дүнгийн тайлан дахь бараа үйлчилгээний бусад зардал мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан дүнгээс 39,899.1 мянган төгрөгөөр, үр дүнгийн	1	49,289.4			1	49,289.4	1	49,289.4				

тайлангийн нийт дүн 7,530.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнагдсаныг залруулав;												
Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгээгүй, 6,829.6 мянган төгрөгөөр төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүй, эргэж төлөгдөх зээл ангиллаар тайлагнасныг залруулав;	1	6,829.6	1	6,829.6			1	6,829.6				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд суралцагчдын тоог тайлагнаагүй байна.	1		1	-			1					
Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээрх цалингийн дүнг давтан тооцоолоход нэг ажилтны орон нутаг ажилласны нэмэгдлийг 385.4 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосныг авлагаар бүртгүүлж залруулсан;	1	385.4			1	385.4	1	385.4				
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 1,775,544.3 мянган төгрөгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд тус тус залруулсан.	1	1,775,544.3	1	1,775,544.3			1	1,775,544.3				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>2,713,978.3</b>	<b>4</b>	<b>1,782,625.9</b>	<b>4</b>	<b>931,352.4</b>	<b>8</b>	<b>2,713,978.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүүг давтан тооцоолоогүй улмаас 28 ажилтанд 162.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон.	1	162.0	1	162.0								
Шалгагдагч байгууллага нь 2016 онд баталсан НБББББ-ийг мөрдөж байгаа нь шинэчлэгдэн батлагдсан стандарт, хууль тогтоомж, заавар журамтай нийцэхгүй байна.							1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>162.0</b>	<b>1</b>	<b>162</b>			<b>1</b>	<b>-</b>				<b>-</b>



## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 148 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 3 удаагийн 171,227.2 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 191,003.7 мянган төгрөгөөр буюу 19,776.5 мянган төгрөгөөр илүү, 1 удаагийн 181,146.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээг 180,705.7 мянган төгрөгөөр буюу 441.1 мянган төгрөгөөр дутуу, 29 удаагийн 637,057.9 мянган төгрөгийн орлогын, 10 удаагийн 103,341.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, дансны хуулгаар нотлогдохгүй болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх шаардлагагүй орлогын 3 удаагийн 41,430.8 мянган төгрөгийн, зарлагын 13 удаагийн 41,078.9 мянган төгрөгийн мэдээлэл байршуулж, ..... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 7 удаагийн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	1	843,126.90			1	843,126.90		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>843,126.90</b>			<b>1</b>	<b>843,126.9</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-					1	-
Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Монгол Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бүрэлдэхүүн, зардлын зориулалт, арга хэмжээний дэлгэрэнгүй заавар”-д төсвийн зарлагыг эдийн засгийн 2 ангиллаар баталснаас шалтгаалж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар	1	-			1	-		

баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Балансын дансны жагсаалт”-ын дагуу тайлагнагдаагүй байна.								
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн и баримтын дүн 18 иргэн, байгууллагад 5,558.7 мянган төгрөгөөр илүү, 4 иргэн, байгууллагад 8,011.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн	1	13,570.2			1	13,570.2		
Хүүхдийн хоол хүнсний материалаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 2,982.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.	1	2,982.1			1	2,982.1		
Нийт 1,576.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг нөөцөлсөн байна.	1	1,576.2			1	1,576.2		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>18,128.5</b>			<b>4</b>	<b>18,128.5</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>861,255.4</b>			<b>5</b>	<b>861,255.4</b>	<b>1</b>	<b>-</b>